



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/32

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, 78.2.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Орон нутгийн өмчийн оролцоотой хувьцаат компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцааг хувьчлах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд “Үүрийн долгио” орон нутгийн өмчийн оролцоотой хувьцаат компанийн орон нутгийн өмчид ногдох 27 хувийн хувьцааг хувьчлах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Р.Машбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Х.Цэнд-Аюуш (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Батнасан (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хяналт хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:

Б.Мөнхзул (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн удирдлага төлөөлөл хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. “Үүрийн долгио” орон нутгийн өмчийн оролцоотой хувьцаат компанийн орон нутгийн өмчид ногдох 27 хувийн хувьцааг хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, хувьчлалын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн, дүнг 2024 оны 3 дугаар улиралд багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

3. Хувьчлах хуулийн этгээдийн нэгж хувьцааны үнийг мэргэжлийн байгууллага /этгээд/-аар тогтоолгож, холбогдох зардлыг хувьчлалын орлогоос гаргах байдлаар зохион байгуулсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

671 0010091